Зураг-5-3-2: Термо камерын зураг

Зураг-5-4-1: Уурын хувиарлагчийн орчим



Зураг-5-4-2: Термо камерын зураг

2) Дулаан алдах хэсгээс алдагдах дулааны тооцоолол

Хүснэгт-5-1: Дулаалгагүй уурын шугам хоолойны шугам алдах хэмжээ

Хэмжээ	Хэсэг	Уурын даралт MPaG	Уурын темп °C	Тасалгааны хэм °C	Хоолойн урт m	1м тутмын дуллан kcal/m·h	Хэсэгийн тоо болон урт	Дулаан алдалтын нийт kcal/h
2"	Gate Valve	8.7	178	15	1.53	736	1 хэсэг	1,126
4"	Gate Valve	8.7	178	15	1.50	1,266	1 хэсэг	1,899
6"	Gate Valve	8.7	178	15	1.92	1,738	6 хэсэг	20,022
8"	Gate Valve	8.7	178	15	2.10	2,194	1 хэсэг	4,607
3"	Press. Reducing Valve	8.7	178	15	1.56	851	2 хэсэг	2,655
6"	Press. Reducing Valve	8.7	178	15	1.78	1,738	1 хэсэг	3,094
4"	Flange	8.7	178	15	0.46	1,266	3 хэсэг	1,747
8"	Flange	8.7	178	15	0.51	1,795	2 хэсэг	1,831
3"	Cap	8.7	178	15	0.30	1,023	3 хэсэг	921
5"	Cap	8.7	178	15	0.30	1,205	2 хэсэг	723
3"	Pipe	8.7	178	15	1.00	851	1 м	851
4"	Pipe	8.7	178	15	1.00	1,266	10 м	12,660
8"	Pipe	8.7	178	15	1.00	2,194	5 м	10,970
							Нийт	63,106

3) Дулаалгагүй хэсгийг дулаалснаар гарах ЭХХ-ийн үр дүнгийн тооцоолол

《Урьдчилсан нөхцөл》

- Дулаан хадгалах чадвар
- Нийт үйлдвэрийн хэмжээнд дээрхи алдагдлыг 1.5 дахин
- Ажиллах хугацаа: 8760 цаг
- Дулаалгын ажлын хөлс Японоос 2 дахин бага

Зураг-5-5: Уурын хавхлага дулаалсан жишээ

《Авах арга хэмжээний агуулга》

Зураг-5-1-д үзүүлсэн хавхлаганы дулаалган цамцнаас гарах үр дүн ихтэй хийхэд хялбар дулаалга.
Уг аргыг санал болгож байна.
Энэ дулаалгын аргыг Япон төдийгүй өөр бусад оронд ч энэ дулаан баригч цамцыг үйлдвэрлэдэг.

《Дулаан алдалтыг бууруулах хэмжээ》

63,106*1.5*8760*0.85/1,000,00 705 Gcal/ж

Энэ бууралтын хэмжээний хувьд уур хүлээн авах хэмжээ 8.2% (705/8,623*100=8.2) тай тэнцүү

《Бүтэн жилийн хэмнэлт》

705*10,600/1,000 = 7,473 мян. Төг (нийт үйлдвэрийн хэмжээгээр тооцсон дүн)

《Хөрөнгө оруулалтын тооцооны дүн》

10,000 мян. Төг (нийт үйлдвэрийн хэмжээгээр тооцсон дүн)

《Хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хугацаа》

10,000/7,473 = 1.3 жил

4) Бусад
   - Уурын шугамны хоолойн тухайд шинэчлэхээр төлөвлөж байгаа бөгөөд (одоогоор төсөв батлуулах шатандаа) тэр ажил хэрэгжих үед авч үзэх нь зүйтэй.
   - Уурын шугам хоолой нийтдээ нимгэн дулаалгатай байгаагаас алдагдах дулаан (уурын алдагдал) ихтэй тул цаашид тохиромжтой зузааныг бодож үзэж хийх ёстой байна.

5-1-2. Уурын алдалт

1) Бодит байдал

Аюулгүй хавхлага дотор талаас алдаж, хавхлага фланц, хөрсний хавхлагаас уур алдагдаж байгааг илрүүлсэн.

Ялангуяа аюулгүй хавхлагаас алдагдаж байгаа нь нүдэн баримжаагаар 200кг/ц орчим уурын алдагдал байгаа гэж харагдсан.

Зураг-5-6: Аюулгүй хавхлагаас алдагдаж байгаа уур

Зураг-5-7: Уур хүлээн авах хэсгийн фланцаас алдагдаж байна.

2) Уурын алдалтаас гарах алдагдал

Алдагдах уурын хэмжээг 200кг/ц гэвэл 846Gcal/ж болох үеийн алдагдлыг мөнгөн дүнд

200*(663-180)*8,760/1,000,000*10,600 = 8,970 мян. Төг/ж

3) Авах арга хэмжээ

Аль болох шуурхайлан тэдгээр алдагдаж байгаа хэсгийг янзлах.

5-1-3. Уурын трапийн үзлэг засвар

1) Бодит байдал

Сүү савалаагны цехийн дотор байгаа уурын 2 трапийг нягтлаж үзсэн бөгөөд (бөмбөлгөн хөвүүрийн төрлийн) гэмтэлтэй байсан.

Зураг-5-8: Ажиллагааны доголдолтой уурын трап

2) Уурын алдалтын хэмжээ болон алдагдал

Алдагдах уурын хэмжээ ойролцоогоор 1кг/ц гэж үзэх бөгөөд Уурын алдагдал дүн нь ажиллагааны цагийн 50% гэвэл дараахи тооцоо гарна.

10*(663-180)*8,760*0.5/1,000,000*10,600 =
224 мян.төг /ж

3) Авах арга хэмжээ

Энэ уурын трапийг засварлах эсвэл солих хэрэгтэй.

Хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалтын эргэн нөхөлт

- Хөрөнгө оруулалт 300 мян.төг
  Эргэн нөхөгдөх х
- угацаа 300/224= 1.3 жил

4) Бусад
Мөн уурын трапийг тогтмол жилд 1-2 удаа үзлэг хийх хэрэгтэй.

5-1-4. Шугам хоолойн дооpоос дээшилж байгаа хэсгийн уурын ус гадагшлуулах төхөөрөмж (уурын трап)

1) Бодит байдал
Уур дамжуулах хоолойн нам хэсгээс дээш өргөгдсөн хэсэгт уурын трап усыг гадагшлуулах боломжгүй болж дараахи асуудал үүсэх магадлалтай.

- Үйлдвэрд хэрэглэх ууранд чийгний агууламж өндөр (Wetness) уурыг өгснөөр төхөөрөмжийн дулаан дамжуулах хүчин чадал буурна.
- агааржуулалтын эхлэх цаг зэрэгт усан цохио амархан үүсдэг.
- Уурын даралтын хэлбэлзэл ихтэй болдог.



Уурын трап

Зураг-5-9: Уурын хоолойн дээш өргөгдсөн хэсэгт уурын ус гадагшлуулагч төхөөрөмж суурилуулах

2) Авах арга хэмжээ
Энэ тохиолдолд ихэнхдээ уур авах тоолуурын өмнө уур ус ялгагч суурилуулдаг.(Зураг-5-9 үзүүлэв)
Гэхдээ ууранд агуулагдах усны хэмжээ (чийгийн хэмжээ) тодорхой бус учраас энэ арга хэмжээ г авсны дараа дулааны хэмжээнд гарах өөрчлөлтийг тооцоолоогүй болно.



Зураг-5-10 : уур авах тоолуурын өмнө уурын ус ялгагч суурилуулах

5-1-6. Уурын даралт буулгагч хавхлагаар үйлдвэрт өгөх уурын даралт буулгаж ДЦС-4-ын уурыг хүлээн авсны дараа үйлдвэрт өгхөөр тоноглогдсон байна.
(Хавсралт-1 уурын схем зурагт үзүүлэв)
Гэвч даралт буулгагчийг тохируулан ашигладаггүйгээс тохиромжтой даралтанд буулгахгүйгээр үйлдвэрт өгч байна.
Төхөөрөмжийн ажиллагаанд асуудалгүйгээр даралтыг буулгаж өгөх нь уурын темпертурыг буулгаж шугам хоолой руу дамжих дулааны хэмжээ буурах тул тэр хэмжээгээр уурын зарцуулалт буурах ёстой.
Гэхдээ бодит байдалд даралт бууруулагчаас хойших даралт мөн буурах магадлалтай даралт нь тодорхой бус болхоор үр ашигийн тооцоолол хийгээгүй болно.

5-1-7. Цаашид уурын шугам хоолой шинэчлэлийн үед өгөх зөвөлгөө

1) Шугам хоолойноос алдагдах дулаан, засварын ажлын хөлс, ирээдүйн төлөвлөгөөндөө сайтар бодож үзэж хоолойн диаметр зэргийг тохируулан багасгах хэрэгтэй.
Тус үйлдвэрийн уурын нөхцөл байдалд уурын шугам хоолойн урсгал хурдныг тооцсон утгыг Хүснэгт 5-2-д үзүүлэв. Мөн шугам хоолойн доторхи тохиромжит хурд 20-30 м/с байна.

снэгт-5-2: Уурын шугам хоолойн хурд тооцоолсон утга

Хоолойн диа	Хоолой доорхи уурын зарцуулалт т/ц		
inch	2	4	6
4	26	52	78
6	12	23	35
8	7	13	20

Тайлбар: Уурын даралт : 0.87MPaG
Уурын харьцангуй хүндийн жин : 0.00114 м3/кг
Хоолойн доторхи тохиромжит хурд : 20-30м/с

2) Ажиллагаанд асуудал болхооргүй бол аль болох багасгаж нийт уртыг багасгах.

3) Бууруулагч хавхлага, уурын трап зэрэгт богино эргэлтийн хоолойг суурилуулж ажиллуулж байх үед ч гэсэн засвар хийж байхаар болгох.
4) Шугам хоолойн дээш өргөгдсөн шаардлагатай хэсэгт уурын ус гадагшлуулагч уурын трап суурилуулах.
5) Дулаалгын тухайд тохиромжтой зузаанаар (хөрөнгө оруулалт ба дулаан алдалтыг зөв тохируулсан байхаар) тогтож шийдэх.
6) Хавхлага болон фланцуудыг ч бас дулаалах
7) Ирээдүй төлөвлөгөө байвал уурын хувиарлагч хоолойд тохирох хэмжээтэй хавхлага суулгаж өгөх
8) Gate Valve ба Globe Valve-ын онцлогийг сайтар ойлгож зөв суулгаж өгөх.

5-2. Хийн компрессор болон гэрэлтүүлэгтэй холбоотой онцлон авах асуудлууд

Хүснэгт-5-3 "Milk үйлдвэр оношилгоо" хийн компрессор/гэрэлтүүлэг

No	Агуулга	Өнөөгийн байдал	Дэвшүүлэх санал	Тоон утга
1	Хийн компрессорын ажиллагааны байдал	30kW-ын компрессороор ON ачаалал/UN ачаалал гэсэн ажиллагаа давтагдаж байна. Гэтэл хэмжилт хийгдэж дуусахын өмнөх хугацаанд 30кВтаас өөр 15кВтын мөхөөдөсний цехийн компрессор ажиллаж ямарч асуудалгүйгээр үйлдвэрийн шаардлагатай хийг түгээж байлаа.	Ердийн ажиллагааны үед 15kW-ын компрессорыг ажиллуулж, 30kW-ын компрессорыг нөөц байдлаар ажиллуулснаар асар их цахилгаан хүчдэл хэмнэх боломжтой байна.	Бүтэн жилд 62,000kW цагийн цахигаан хүчдэл хэмнэх боломжтой болно.
2	Хий алдалт	①Хийн компрессорын орчимд 4 цэгт хий алдагдаж байна. ②Тарагны цехийн шугамны хийн төхөөрөмжнөөс хий алдагдаж байсан.	①Яаралтай засварлах. ②Илэрсэн газруудыг алдалтыг янзлахын зэрэгцээ хэт авианы алдалт хэмжигч худалдан авч ашид тогтмол үзлэг засвар хийх нь зохистой.	Баримжаа утга 1 цэгт 0.4kWh/h орчим алдалт гээд нийт 5 цэгт тооцож үзвэл, (0.4 X 5) X 6,000цаг = 12,000kWh/жил
3	Хийн даралт	7.5-6.9 бар	Том асуудал биш ч гэсэн 0.5 бараар буулгаж ЭХ хэмнэх боломж байгаа бөгөөд эхний ээлжинд томоохон асуудлуудыг шийдэж ирээдүйд авах арга хэмжээ гэж үлдээх	—
4	Коридорын гэрэлтүүлэг	Шатны гэрэлтүүлэг сүүн гэрэл бүхий хүний хөдөлгөөн мэдрэгчтэй унтраалгатай байсан.	Хөдөлгөөн мэдрэгч унтраалгатай байгаа нь туйлын сайн ЭХ хэмнэлт болж өгдөг бөгөөд улайсдаг гэрлүүдийг аль болох яаралтай сүүн гэрлээр солих хэрэгтэй гэж үзэж байна.	—
5	Цех тус бүрийн гэрэлтүүлэг	Байгалийн гэрэл оруулах цонхыг хэд хэдэн цехэд суурилуулсан байсан ба ихэнх газарт сүүн гэрэлтүүлэг тавьсан байсан.	Гэрэлтүүлэгтэй холбоотой цахилгаан хэмнэлтийг нэлээд сайн нэвтрүүлсэн байгаа нь туйлын зөв зүйтэй гэж үзэж байна.	—
6	Улайсдаг гэрлийг өдрийн сүүн гэрлээр солих	Үйлдвэр дотор улайсдаг гэрэл зарим нэг газар харагдсан.	Үйлдвэр доторхи гэрлийг сайтар нягталж үзэж улайсдаг гэрлийг сүүн гэрлээр шинэчлэх ёстой байдаг.	—

5.2 Хийн компрессорын төхөөрөмж

Шахагдсан хийтэй хийн компрессорын хэмжилтийн дүнг өөр хүснэгтээр үзүүлсэн байгаа бөгөөд компрессорын өөрчлөлт хий алдалтын тухайд дараах байдлаар тэмдэглэв.

(1) Компрессорын ажиллагаа өөрчлөлт

Ердийн үед сүүний бүтээгдхүүний хэсэгт суурилагдсан 30кВт-ын компрессорыг ажиллуулж байгаа ачаалалт болон ачаалалгүй үеийн ажиллагаа бараг л 50% тай байсан.

Үүнтэй харьцуулахад хэмжилт дуусах тэр мөчид 30кВт ын компрессорын оронд мөхөөлдөсний цехийн 18.5 кВт-ын компрессор автоматаар ажиллаж ойролцоогоор 7 минут асуудалгүй үргэлжлүүлэн ажиллаж байгаа нь бичигдэн үлдсэн байна.



Энэ удаад хэмжилт хийж эхэлсэн 10:56 минутаас ойролцоогоор 3 цагийн ажиллагааны бичлэгээс үзэхэд 30кВт ын компрессорыг нөөц болгон ажиллуулж 15кВт-ын компрессорыг ердийн өдөр тутмын болгох боломжтой гэж үзэж байна.

Энэ боломжийг эцсийн байдлаар шийдхийн тулд 2-3 өдөр компрессорын ажиллагаанд хэмжилт хийж бичлэгийн дүнд үйлдвэрийн хийн компрессорын мэргэжилтэн нь үзлэг хийж шийдвэрлэвэл зохилтой.

15kW-ын компрессорын ердийн өдрийн ажиллагаанд зөвшөөрөгдсөн тохиолдолд цахилгаан хүчдэл дараахи байдлаар хэмнэгдэнэ.

(Өнөөгийн байдал)

Ачааллын үед $\sqrt{3}\times0.38V\times55A\times0.85\times4000$цаг＝123,076кВ/ц

Ачаалалгүй үед $\sqrt{3}\times0.38V\times35A\times0.70\times4000$цаг＝64,499кВ/ц

Нийт 123,076кВ/ц－64,499кВ/ц＝187,575кВ/ц

(Өөрчлөлтийн дараа)

Жилд 8000 цаг, нийт ачаалалтай ажиллагаатай гэж таамаглаж

Ачааллын үе $\sqrt{3}\times0.38V\times28A\times0.85\times8000$цаг＝125,313кВ/ц

(Хэмнэлтийн хэмжээ)

187,575кВ/ц － 125,313кВ/ц ＝62,262кВ/ц

Жилд ойролцоогоор 62,000кВ/ц цахилгаан хүчдэл хэмнэх боломжтой болно.
Мөн хий алдагдаж байгааг зогсоосноор хэмнэлтийн хэмжээ нэмэгдэж 15кВ-ын 1 компрессороор ажиллуулахад амар болох болно.

(2) Шахагдсан хий алдагдаж байгаа газруудыг олж тогтоох
Хэт авианы хий алдалт хэмжигчийг ашиглан шахагдсан хийний алдалтыг олж тогтоосон дүнд компрессорын ойр орчимд 4 газарт, тарагны савалгааны цехэд 1 газар нийт 5 газар байлаа.

1 газарт ойролцоогоор 4м3/ц гэвэл энэ нь 0.4кВ/ц -ын цахилгаан хүчдэлээр нэмэгддэг. Өөрөөр хэлбэл алдаж байгаа 1 газрыг олж засварласанаар жилийн цахилгаан хүчдэл хэмнэх боломжтой.

0.4кВ/ц×5×8000ц＝16000kВ/ц

Гэвч энэ удаагийн үзлэгээр үйлдвэрийн нийт хий хэрэглэгдэж байгаа газруудыг хамруулж чадаагүй учраас цаашид алдагдаж байгаа газруудыг хайж үзснээр илүү олон газар илэрснээр цахилгаан хэмнэлтийн хэмжээг төдий их болгож болно гэсэн үг юм.

(3) Хийн компрессорын ажиллагаа хэмжилтийн бичлэг
Энэ удаа хийсэн хэмжилтийн бичлэгийг хавсралт-3 үзүүлэв.

5.4 Гэрэлтүүлэг
Гэрэлтүүлэгийн тухайд үйлдвэрийн таазнаас байгалийн гэрэлтүүлэг цонх суулгаж өгсөн өдрийн хугацаанд гэрлийн хэмнэлт гарах ба шатны гэрлийг хүний хөдөлгөөн мэдрэгч бүхий унтраалга хийсэн байгаагаас нэлээд эрчимтэйгээр ЭХ хэмнэлтийн үйл ажиллагааг явуулж байгааг ажигласан.
Гэвч улайсдаг гэрлийг зарим нэг газарт тавьсан байгааг ойрын хугацаанд сүүн гэрлээр солих нь эрчим хүч хэмнэлтэнд үр дүнгээ өгнө гэж үзэж байна.
Гэрэлтүүлэг төхөөрөмжийн үзлэг хийсэн дүнг хавсралтанд үзүүлэв.



MILK JSC Үйлдвэрийн уурын системийн схем зураг

Хавсралт-2



Milk JSC Үйлдвэрийн хийн компрессорын схем зураг

Хавсралт-3



Хэмжилт 10:56-гаас 13:45 цаг хүртэл



Хэмжилт 10:56-гаас 11:26 цаг хүртэл



Хэмжилт 13:18-гаас 13:47 цаг хүртэл

"Алтан тариа" ХК
Эрчим хүч дулаан хэмнэлтийн оношлогооны дүнгийн тайлан

2011 он 6 сар

Монгол улс
Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл
Эрчим хүч дулаан хэмнэлтийн баг

1. Эрчим хүч дулаан хэмнэлт (ЭХДХ)-ийн оношилгооны дүнгийн нэгтгэл

1-1. Эрчим хүч хэмнэлтийн агуулга

Одоо уурийн хувьд ДЦС 4-тэй тогтсон хэмжээтэйгээр хүлээн авах гэрээтэй байдаг ба уурын ЭХДХ-д авч явуулах арга хэмжээг явуулсан ч тэр хэмжээгээр агаарт цацагдан хаягдах нь ихсэх болно Дараах агуулга нь хэрэглээний хэмжээнд тохируулан уурын төлбөрийг төлдөг гэрээг шинэчлэн өөрчилсөн тохиолдлоор бодож тооцоолсон дүн юм.

Хүснэгт-1-2 : ЭХДХ саналын агуулга

No.	Агуулга	ЭХ-ний төрөл	ЭХ-ний зарцуулалтыг багасгах /жил		Үр ашиг 1000төг/ж	Хөрөнгө оруулалтын дүн 1000төг	Хөр.оруулалтын эргэн төлөгдөх хугацаа жил	Тайлбар
1	ДЦС 4-с уур хүлээн авах тухай гэрээг шинэчлэн өөрчлөх	уур			-	-	-	
2	Уурын хоолойн дулаалгыг сайжруулах							
1)	Дулаалга хийгдээгүй болон дулаалга нь муудсан хоолойн дулаалгыг сайжруулах	уур		Gcal	1,929	4,000	2.1	
2)	Дулаалгын аргыг сайжруулах зузаалах	уур		Gcal	1,587	4,000	2.5	
3	Хоолойн дээш өргөгдсөн хэсэгт уурын трап суурилуулах	уур			-	-	-	Үр ашигийг үнэлэх боломжгүй
4	уурын тоолуурын урьд талд уурын ус ялгагч төхөөрөмж суурилуулах	уур			-	-	-	Үр ашигийг үнэлэх боломжгүй
5	Тэжээлийн үйлдвэрийн уурын ус ялгагчыг жижгэрүүлэх	уур		Gcal	630	3,000	4.8	
6	Гурилын үйлдвэрийн уураар агаар халаагчид уурын трап суурилуулах	уур			-	-	-	Цаашид авч хэлэлцэх асуудал
7	Гурилын үйлдврийн халуун агаарын сувгын дулаалга	уур			-	-	-	Цаашид авч хэлэлцэх асуудал
8	Гурилын үйлдврийн 1 болон 5 давхрын хийн компрессорын хоолой холбосноор 1 болгон ажиллуулах	цахилгаан		kWh	5,456	3,000	0.5	
9	Шахагдсан хий алдагдаж буй газруудыг янзлах	цахилгаан		kWh	1,056	0	0	Хий алдаж буй газрыг хамгаалсан тул хөр.оруулалтын хэмжээг 0 гэсэн.
10	Шахагдсан хийн даралтыг буулгах	цахилгаан			-	-	-	Цаашид авч хэлэлцэх асуудал
11	Улайсдаг гэрлийг өдрийн гэрлээр солих	цахилгаан			-	-	-	Үр ашигийг үнэлээгүй.

1-2. ЭХДХ боломжит нөөц (Үр дүн тоон утгаар илэрхийлэгдэх зүйлийг зөвхөн хамруулав)

Хүснэгт-1-2-д үйлдвэрийн ЭХДХ-ийн нөөц бололцоог үзүүлсэн бөгөөд тоон утгаар илэрхийлэгдээгүй зүйлс байгаа учраас тэр хэмжээгээр илүү их нөөц байгаа гэж үзэж болох тул илүү их боломж нөөц байгаа гэж үзэж байна.

Хүснэгт-1-2: Үйлдвэрийн ЭХДХ-ийн нөөц боломж

ЭХ-ний төрөл	Жилийн зарцуулалт		Хэмнэх хэмжээ	Хэмнэлт хувь %	Хэмнэлт мөнгөн дүнгээр мян. Төг	Хөрөнгө оруулалт мян. Төг	Хөрөнгө оруулалт нөхөн төлөгдөх хугацаа Жил	Тайлбар
Уур		Gcal	360 Gcal	#DIV/0!	4,147	11,000	2.7	
Цахилгаан		kWh	74,000 kWh	#DIV/0!	6,512	3,000	0.5	
		Gcal	64 Gcal					
Халуун ус		Gcal	- Gcal	-	-	-	-	
Нийт	0	Gcal	423 Gcal	#DIV/0!	10,659	14,000	1.3	

Анхаарах Цахилгааны төлбөр болон уурын төлбөрийн хувьд дараахи тоогоор авч үзэн тооцоолов.

- Цахилгааны төлбөр : 88 төг/кВт
- Уурын төлбөр : 11,870 төг/Гсал

2. Үйлдвэрийн товч танилцуулга

2-1. Үйлдвэрийн товч танилцуулга

1) Компаний нэр Алтан тариа ХК
2) Эзэмшлийн байдал Хувь
3) Хаяг
4) Гол бүтээгдэхүүн
   - гурил
   - нунтаг төрлийн зүйлс
   - тэжээл
5) Эрчим хүч зарцуулалт
   (1) Цахилгаан (2010 он) kWh
   (2) Уур (2010 он) GJ
   (3) Халуун ус (2010 он) GJ

2-2. Үйлдвэрийн байрлалын зураг

from Google Earth

2-3. **Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн байдал**

Хэрэглээний тоно	Уурын тоног төхөөрөмж						
төхөөрөмж	Хангадаг газар		ДЦС4				
	Уурын даралт(Оношлогооны үед)	bar	10.1				
	Уурын темп (Оношлогооны үед)	°C	163 （ханасан）				
	Халуун усны тоног төхөөрөмж						
	Хаанаас авдаг		уураар хангагч компани				
	Уурын даралт(Оношлогооны үед)	bar					
	Уурын темп (Оношлогооны үед)						
	Буцаах үеийн темп (Оношлогооны үед)						
	Хийн компрессор		1	2			
	Үйлдвэрийн загвар, марк		KAESER ASD-57T	KAESER ASD-57T			
	Агаарын хэмжээ	Nm3/min	264	264			
	Даралт	MPaG	11	11			
	Норматив чадал	kW	30	30			
	Цахилгаан хүлээн авах трансформатор						
	Анхдагч/ 2дагч талын хүчдэл						
	Чадал	kVA					
	Суурилуулсан он						

Гэрэлтүүлэг	Гэрэлтүүлэх хэлбэр		Incandescent	Fluorescent сса	Fluorescent (HF)	HID	Hg	
	Гэрэлтүүлэх тоноглолын тоо							
	Цахилгааны дундаж гүйдэл	W						

Бусад эрчим хүчний хэрэглээ ихтэй тоног төхөөрөмж	

3-4. **Эрчим хүчний үнэ**

1) Цахилгаан Tg/kWh
2) Уур Tg/Gcal
3) Халуун ус Tg/Gcal
4) Хаягдал усны төлбөр: Tg/m3 (санаа авах)

2-4. ЭХ-ний хэрэглээний хэмжээ болон ЭХ-ний эх үүсвэрийн нэгж

Он/Сар		Цахилгааны зарцуулалт		Уурын зарцуулалт	Халаалтын зориулалттай халуун усны зарцуулалт	Усны зарцуулалт		Үйлдвэрлэлийн хэмжээ/Борлуулалтын дүн		ЭХ-ний эх үүсвэрийн нэгж			
										Цахилгаан		Уур	
		Оргил үеийн ЭХ kW	сарын ЭХ-ний хэрэглээ kWh	Gcal	Gcal	Сүлжээний ус m3	Гүний ус m3	Үйлдвэрлэлийн хэмжээ	Борлуулалтын дүн	Үйлдвэрлэлийн суурь	Борлуулалтын суурь	Үйлдвэрлэлийн суурь	Борлуулалтын суурь
2010	1												
	2												
	3												
	4												
	5												
	6												
	7												
	8												
	9												
	10												
	11												
	12												
нийт		-	0	0	0	0				-	-	-	-



3. ЭХДХ-ийн оношлогооны ажлын агуулга

3-1. Ерөнхий

1) Хэрэгжүүлсэн өдөр: 2011 оны 6 сарын 8
2) Оношлогч: Мэргэжилтэн Такахаши Сүсүми
   Мэргэжилтэн Хигаки Садао
3) Оролцогч: НАЧА-ын мэргэжилтэн Цолмон

3-2. Уурын тоног төхөөрөмж

1) Тоног төхөөрөмжийн байдлыг үзэж нягтлах
2) Тоног төхөөрөмжийн схем зураг гаргах
3) Ажиллагааны байдлыг шалгах
4) Шугам хоолойн дулаалгын байдлыг магадлах
5) Уурын трапны үзлэг шалгалт (Сонгох)
6) Бусад

3-3. Хийн компрессор

1) Хийн компрессорын цахилгаан гүйдэл, даралтыг тасралтгүй хэмжих
2) Төхөөрөмжийн бүдүүвч, схем зураг гаргах
3) Төхөөрөмжийн болон ажиллагааны байдлыг магадлан шалгах
4) Шахагдсан хийн алдалтын байдалд шалгалт хийх

3-5. Гэрэлтүүлэг

1) Тоноглолын байдлыг шалган үзэх
2) Тоноглолын ашиглалт, хяналтын байдлыг шалгах

4. Монгол талын оролцогчдод ЭХДХ-ийн оношлогоо болон хэмжилтийн багаж ашиглалтын талаар зааж сургах

НАЧА-ны 1 мэргэжилтэн болон үйлдвэрийн ажилтанд ЭХДХ-ийн оношлогооны технологи болон ЭХДХ-ний оношлогооны хэмжилтийн багаж ашиглах зааварчилгаа өгч ажилласан.
Хэмжилтийн багаж ашиглалтыг монгол талын оролцогчдоор хийлгэхийг чухалчлахын зэрэгцээ үйлдвэрийн холбогдох хүмүүст мэдрэгч төхөөрөмжтэй болгоомжтой харьцаж ажиллахыг хүссэн.
Технологийн зааварчилгаа өгч байгааг зургаар үзүүлэв.

Зураг 4-1 : Хэт авианы хий алдалт хайгчаар шахагдсан хийн алдагдлыг шалгаж байгаа нь

Зураг 4-2 : Термо камерыг ашиглах талаар заавар өгч байгаа нь

Зураг 4-3 : Хийн компрессороор байнгын хэмжилт хийж байгаа нь

5. ЭХДХ-ийн оношлогооны дүн

5-1. Уурын төхөөрөмж

ДЦС-4 -өөс ууraар хангагддаг. (Хавсралт-1 схем зурагт үзүүлэв)

Уурын төхөөрөмжийн хувьд ЭХДХ-ийн талаас дараахи доголдолтой асуудлууд байна.

1) ДЦС 4 -тэй 2 тц-ын уурыг хүлээж авах гэрээтэй бөгөөд уурын хэрэглэж дуусаагүй илүүдэл хэсэг нь агаарт цацагдаж байна.
2) Шугам хоолойн дулаалгын байдал сайнгүй байгаа тул ихээхэн хэмжээний дулаан алдагдаж байна.
   - хаах хавхлага, фланц залгаас, хоолой зэрэг хэсэгт
   - дулаалгын зузаан хангалтгүй, дулаалах арга буруу
3) Уурын хоолойн сүлжээ холбоосны шаардлагатай хэсэгт уурын усыг гаргах уурын трапыг суурилуулаагүй байгаа.
4) Уур нь чийглэг ихтэй байгаа тул авч байгаа уурын тоолуур заалт зөрүүтэй байх магадлалтай.
5) Тэжээлийн үйлдвэрийн уурын ус ялгагч нь багтаамж ихтэй байгаа бөгөөд гадаргуугаараа дулаан алдагдах нь их байгаа.

5-1-1. ДЦС 4-тэй хийсэн уур хүлээн авах тухай гэрээ

ДЦС 4 -тэй 2 т/ц-ын уурыг хүлээж авах гэрээтэй бөгөөд уурын хэрэглэж дуусаагүй илүүдэл хэсэг нь агаарт цацагдаж байна. （Зураг 5-1-1, зураг 5-1-2 үзүүлэв）

Зураг- 5-1-1：Илүүдэл уурын агаарт цацагдан алдагдаж буй байдал （2011 он 6 сар）

Зураг- 5-1-2：Илүүдэл уурын агаарт цацагдан алдагдаж буй байдал （2011он 3 сар ）

Ийм байдал нь үйлдвэрийн ууртай холбогдох ЭХДХ-д авч явуулах арга хэмжээг эрчимтэй хэрэгжүүлэхэд хүндрэл учруулах тул цаашид шийдвэрлэх асуудал болгон гэрээний талыг өөрчлөх шаардлагатай байна. Мөн дараахи ууртай холбогдох ЭХДХ-ийг сайжруулах санал нь ердөө уур ашиглалтын тухайд, түүний хэрэглээний хэмжээг багасгахад чиглэсэн арга хэмжээний талаар бичсэн бөгөөд энэ талаар үр дүнд хүрэхийн тулд гэрээгээ сайжруулсан нөхцөлтэй байх юм.

5-1-2. Уурын шугам, хоолойн дулаалгыг сайжруулах

1) Одоогийн байдал

Уурын хоолойн хавхлага, фланцын дулаалга сайнгүй, мөн дулаалга хийгдээгүй хоолой ч байна. Иймд эдгээр зүйлээс ихээхэн хэмжээний дулаан алдагдаж байна.
（Термо камерын зургыг үзнэ үү）

Мөн шугам хоолойн дулаалгын зузаан хангалтгүйн дээр дулаалга нь муудсан газар байгаа нь ажиглагдсан.

Зураг-5-2-1:Уурын тоолуурын орчин



Зураг-5-2-2:Зүүн талын термографикын зураг



Зураг-5-3-1:Гурилын үйлдвэрийн агаар халаагчийн уурын хувиарлагч



Зураг-5-3-2:Зүүн талын термографикын зураг

Зураг-5-4-1:Тэжээлийн үйлдвэрийн уурын ус гадагшлуулагчын амсарын хэсэг



Зураг-5-4-2:Зүүн тал голын термографизийн зураг



Зураг-5-4-3:Тэжээлийн үйлдвэрийн уурын ус гадагшлуулагч болон уурын хоолойн орчны зураг

2) Дулаалгагүй газраас алдагдах дулааны тооцоолол

Дулаалгагүй газар (дулаалга нь авагдсан хэсэг орно)-аас алдагдах дулааны хэмжээ нь Хүснэгт 5-1 үзүүлсэнчлэн болно.

Хүснэгт 5-1：Дулаалгагүй болон дулаалга нь муудаж авагдсан уурын шугамаас алдагдах дулааны хэмжээ

Хэмжээ	Хэсэг	Уурын даралт MPaG	Уурын температур °C	Тасалгааны хэм °C	Хоолойн урт m	1 м тутмын дулаан kcal/m･h	Хэсгийн тоо болон урт	Нийт дулаан алдалт kcal/h
1"	Welded Ball Valve	10.06	183	20	0.50	307	4 хэсэг	614
1-1/2"	Welded Ball Valve	10.06	183	20	0.50	420	4 хэсэг	840
4"	Welded Ball Valve	10.06	183	20	0.50	933	1 хэсэг	467
2"	Flanged Globe Valve	10.06	183	20	2.10	527	3 хэсэг	3,320
2"	Press. Reducing Valve	10.06	183	20	1.56	527	2 хэсэг	1,644
2"	Strainer	10.06	183	20	1.78	527	1 хэсэг	938
4"	Flange	10.06	183	20	0.46	1,301	1 хэсэг	598
6"	Flange	10.06	183	20	0.51	1,301	2 хэсэг	1,327
4"	Pipe	10.06	183	20	1.00	933	10 м	9,330
							нийт	18,464

3) Дулаалгагүй хэсгийг дулаалсанаар гарах ЭХДХ-ийн дүнгийн тооцоолол

[Нөхцөл]

- Дулаан хадгалах хувь: 85%
- Үйлдвэрийн хэмжээнд үзвэл дээрхи алдагдлаас 1.5 дахин их
- Ажиллах хугацаа: 8760 цаг
- Тэжээлийн үйлдвэрийн уурын коллектор
- Дулаалгын ажлын зардал: Японоос 1/2 дахин их

Зураг-5-5: Уурын хавхлагыг дулаалсан байдал

[Авах арга хэмжээний агуулга]

Зураг-5-1-д үзүүлсэн хавхлагад дулаан баригч цамцыг хийснээр үр дүн сайтай, хийхэд хялбар тул уг дулаалгын аргыг хэрэглэхийг санал болгож байна. Дулаан баригч цамцыг хэрэглэх аргыг Япон төдийгүй өөр бусад оронд ч үйлдвэрлэн хэрэглэдэг.

[Дулаан алдалтыг бууруулах хэмжээ]

16,251*1.5*8,760*0.85/1,000,000 = 182 Gcal/жил

Энэ бууралтын хэмжээний хувьд уур хүлээн авах хэмжээ 8.2% （705/8,623*100=8.2）-тай болно.

[Бүтэн жилийн хэмнэлт]

182*10,600/1,000 = 1,929 мян.төг/ж (нийт үйлдвэрийн хэмжээнд тооцсон дүн)

[Хөрөнгө оруулалтын тооцооны дүн]

4000 мян.төг (нийт үйлдвэрийн хэмжээнд тооцсон дүн)

[Хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хугацаа]

4,000/1,929 = 2.1 жил

5-1-2-2. Дулаалгын аргыг сайжруулах (дулаалгыг зузаалах)

1) Өнөөгийн байдал

Одоо 10 мм-ын зузаантайгаар шилэн хөвөнгөөр дулаалах аргыг ихэвчлэн хэрэглэсэн байна.
Одоогийн дулаалгын аргыг хэрэглэснээр дулаан хадгалалтын тооцооны дүн 81% орчим бөгөөд ердийн дулаалгатай харьцуулахад 10% орчимоор доогуур байна.
Одоогийн дулаан хадгалах чадварын тооцоог доор үзүүлэв.

[Тооцооллын нөхцөл]

Дулаалгын материал : шилэн хөвөн
Дулаалгын зузаан : 10 мм
Шугам хоолойн хэмжээ: 4 инч
Уурын даралт : 10.6bar（183ºC）
Гаднах орчны температур : 20ºC
Салхины хурд : 0 м/с
Тусгах чадварын хувь : 0.90

[Тооцооллын дүн]

Уурын нөхцөл байдлаас дулаан хадгалалтын тооцооны программаар тооцоолоход, энэ тохиолдолын дулаан хадгалалт нь 81%-тай байна.
Мөн шугам хоолойн хэмжээ өөрчлөгдсөн ч дулаалгын зузаан өөрчлөгдөөгүй бол дулаан хадгалалтын үзүүлэлт нь бараг ижил байх юм.

2) Сайжруулалт болон сайжруулалтын үр дүн

Дулаалгын зузаан нь дулаан хадгалах тохиромжтой зузаан （хөрөнгө оруулалтын хэмжээ болон эдийн засгийн хувьд хамгийн зөв зохистой байх）-ыг сонгох шаардлагатай бөгөөд зузааныг 30 мм болгосон тохиолдолд сайжрах үр дүнг тооцоолбол доорхи байдалтай байна.
Гэхдээ дараахи сайжралтын үр дүн нь ДЦС 4-тэй хийсэн гэрээгээ шинэчлээд, хэрэгцээнийхээ хэмжээнд тааруулан уурын төлбөрөө төлдөг хэлбэрт оруулах гэсэн нөхцөлтэйгээр тооцоолсон болно.

Дулаалгын материал : шилэн хөвөн
Дулаалгын зузаан : 10ммТ→30ммТ
Шугам хоолойн хэмжээ/урт: 4inch/150m

Анхаарах : 1) бусад хэмжээний хоолойг оруулаад 4 инч, 150 м гэж тооцоолсон болно.
2) Газар доорхи шугам хоолойг тооцоохгүй.

Уурын даралт : 10.06bar（183ºC）
Гаднах орчны температур : 20ºC
Салхины хурд : 0m/s
Тусгах чадварын хувь : 0.90
Уурын нэгжийн үнэ : 10,600 төг/гКал

[Тооцооллын дүн]

Одоогийн байдалд болон сайжруулсаны дараах цацагдаж буй дулааны хэмжээ болон дулаан хадгалалтын АҮК

Хүснэгт-5-2. Одоогийн байдал болон сайжруулсаны дараахи дулаан алдагдлын хэмжээ, дулаан хадгалалтын АҮК

	Цацагдаж буй дулаан kcal/m	Дулаалгын АҮК %	Тайлбар
О.байдал（10ммТ）	178.7	80.8	
С.дараа（30mmТ）	83.6	91.0	
Дулаалгагүй	932.5	0	Reference

Сайжруулсанаар цацагдаж хаягдах дулааны багасах хэмжээ
(178.7-83.6)*150 = 14,265 kcal/h
125.0 Gcal/h

Сайжруулсанаар уурын алдагдалын багасах хэмжээ
[Сайжруулсаны давуу тал]
15,265*8,760/1,000,000*11,870/1,000 = 1,587 мян.төг/ж

[Хөрөнгө оруулалтын хэмжээ ерөнхий тооцоо]
4,000 мян.төг

[Хөрөнгө оруулалтын эргэн төлөлдөх хугацаа]
4,000/1,587= 2.5 жил

5-1-3. Хоолойн дээшээ өргөгдсөн хэсэгт уурын ус (конденсат) гадагшлуулагч төхөөрөмж (уурын трап)-ыг суурилуулах

1) Одоогийн байдал
Уурын хоолойн нам хэсгээс дээш өргөгдсөн хэсэгт уурын трап суурилагдаагүй байгаа тул уурын усыг гадагшлуулах боломжгүй болж, дараахи асуудал үүсэж болзошгүй юм.

- Үйлдвэрт хэрэглэх ууранд чийгний агууламж ихтэй уур тархах тул төхөөрөмжийн дулаан дамжуулах чадвар буурна.
- Агааржуулалтыг эхлэх үед усан цохио амархан үүсдэг.
- Уурын даралтын хэлбэлзэл ихтэй болдог.



Зураг-5-6: Уурын хоолойн дээш өргөгдсөн хэсэгт уурын ус гадагшлуулагч төхөөрөмж суурилуулах

2) Авах арга хэмжээ
Диаметр өргөнтэй уурын хоолойн (жишээ нь, 3 инчээс дээш өргөнтэй) дээшээ өргөгдсөн хэсэгт Зураг 5-6-д үзүүлсэнчлэн уурын усыг гадагшлуулагч төхөөрөмжийг суурилуулах.

5-1-4. Уур хүлээн авах тоолуурын урьд хэсэгт уурын ус ялгагчыг суурилуулах

1) Одоогийн байдал
Уур хүлээн авах тоолуурын урьд хэсэгт уурын ус гадагшлуулагчыг суурилуулаагүйгээс уур хүлээн авах тоолууроор дамжин өнгөрөх уур нь ихээхэн чийгтэй байх юм.
Үйлдвэр хүлээн авч байгаа уурынхаа төлбөрийг дулааны хэмжээнд үндэслэн тооцдог боловч бодит байдлаас илүү их зарцуулалт тооцогдож байгаа бөгөөд нэгж жингийн ууранд ноогдох дулааны хэмжээ нь бага байгаа учраас бодитоор хүлээн авах дулааны хэмжээнээс хамаагүй их хэмжээний дулаан хүлээн авч байгаа болох юм.

2) Авах арга хэмжээ
Энэ тохиолдолд ихэнхдээ уур авах тоолуурын өмнө уурын ус гадагшлуулагчыг суурилуулдаг. (Зураг 5-7-д үзүүлэв)
Гэхдээ ууранд агуулагдах усны хэмжээ (чийглэгийн хэмжээ) тодорхой бус учраас энэ арга хэмжээг авсны дараа дулааны хэмжээнд гарах өөрчлөлтийг тооцоолоогүй болно.



Зураг-5-7: Уур авах тоолуурын өмнө уурын ус гадагшлуулагчыг суурилуулах

Зураг-5-8: Уурын ус гадагшлуулагч төхөөрөмжийн жишээ

5-1-5. Тэжээлийн үйлдвэрийн уурын ус ялгагч төхөөрөмжийг жижгэрүүлж, бага оврын болгох

1) Одоогийн байдал

Тэжээллийн үйлдвэрийн уурыг хүлээн авах газарт Зураг-5-9-т үзүүлсэнчлэн багтаамж ихтэй уурын ус ялгагчийг суурилуулсан байгаа бөгөөд, өнгөн гадаргуу нь том бас шилэн хөвөнгийн дулаалгын зузаан нь 20 мм орчим нимгэн байгаа учраас ихээхэн дулаан алдагдал үүсч байгаа юм.

Зураг-5-9：Тэжээлийн үйлдвэрийн

2) Авах арга хэмжээ

Одоо суурилагдсан байгаа овор багтаамж ихтэй уурын ус ялгагчийг Зураг-5-10-д үзүүлсэнчлэн бага оврын уурын ус гадагшлуулагчаар сольж, дулаан алдагдлыг багасгаж болно.



Шинэчлэн өөрчлөхөөс өмнөх　　Шинэчлэн өөрчилсөний дараа

Зураг-5-10：Шинэчлэн өөрчилсөн байдал

3) Сайжруулалтын үр дүнгийн тооцоо

[Тооцооллын нөхцөл]

Суурилуулсан байгаа уурын ус ялгагч

Багтаамж：	2 м3	
Гадаргуун талбай：	10 м2	
Дулаан хадгалалт	шилэн хөвөн,	10ммТ

Шинээр суурилуулах уурын ус ялгагч

Гадаргуун талбай：	2 м-ын урттай 2 инчийн хоолой той адилхан гадаргуун талбай тай гэж үзэх （0.4м2 орчим）	
Дулаан хадгалалт：	шилэн хөвөн,	30ммТ
Уурын даралт:	10.06	бар (183ºC)
Гаднах орчны температур：	20 ºC	
Салхины хурд:	0 m/s	
Тусгах чадварын хувь（Emissivit	0.90	
Уурын нэгж	10,600	Tg/Gcal

	Гадаргуун талбай	Дулаалгын зузаан	Хаягдаж буй дулааны хэмжээ kcal/h		
	м2	мм	эх бие	амсарын хэсэг	Нийт
Өөрчлөхийн өмнө	10	20	4,836	1,327	6,163
Өөрчилсөний дараа	0.4	30			102
Зөрүү					6,061

53.1 Mcal/y

[Сайжруулсаны давуу тал]
6,061*8,760/1,000,000*11,870/1,000 ＝ 630 мян.төг/жил

[Хөрөнгө оруулалтын хэмжээ （ерөнхий тооцоо）]
3,000 мян.төг

[Хөрөнгө оруулалтын эргэн нөхөгдөх хугацаа]
3,000/630＝ 4.8 жил

5-1-6. Гурилын үйлдвэрийн уураар агаар халаагч төхөөрөмжид уурын трап суурилуулах
Гоймонгын үйлдвэрийн хатаах дамжилгад ашиглагддаг халуун агаар нь хатаах дамжлагаас ирэх эргэлтийн агаарыг уураар агаар халаагч төхөөрөмж 4 -өөр халаагаад хатаах дамжлага уруу явуулдаг. Энэ төхөөрөмжийн уурын ус гадагшлуулах талд уурын трапыг суурилуулаа гүй тул уур алдагдаж, уур үүсэлтийн нууц дулааныг үр дүнтэй ашиглаагүй байх магадлалтай юм. Гэвч энэ алдагдлын хувьд одоогийн нөхцөлд тооцоолол гаргах боломжгүй байгаа боловч цаашид энэ асуудлыг хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байна.

5-1-7. Гурилын үйлдвэрийн халуун агаарын сувгын дулаалга
Гурилын үйлдвэрийн хатаах дамжлагад ашиглагддаг халуун агаарын сувгын хувьд дулаалга хийгдээгүйн улмаас дулаан ихээхэн хэмжээгээр алдагдаж байна.
Одоогийн байдлаар ажиллуулах нөхцөл байдал （буцаж ирэх эргэлтийн агаарын хэмжээ зэрэг）нь т одорхойгүй байгаа тул цаашдаа авч хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байна.

6-2. **Хийн компрессор болон гэрэлтүүлэг**

Хийн компрессор болон гэрэлтүүлэгтэй холбоотой ЭХДХ-ийн оношлогоонд хамаарах асуудлыг хүснэгт 5-5-д үзүүлсэн болно.

Хүснэгт-5-5 "Алтан тариа ХК-ний оношлогоо"
Хийн компрессор / гэрэлтүүлэг

No	Агуулга	Өнөөгийн байдал	Дэвшүүлэх санал	Тоон утга
1	Хийн компрессорын ажиллагааны байдал	Гурил үйлдвэрлэх дамжлагад 1 давхарт 45 кВт-ын, 5 давхарт 18.5 кВт-ын компрессорыг суурилуулсан ба эдгээр 2 компрессор нь тус тусдаа байнгын ажиллагаатай байдаг.	1 давхарын хийн компрессорт 2 цаг хэмжилт хийхэд шахагдсан хийг илгээх ачаалалтай болон агаар илгээх ачаалалгүй зөвхөн цахилгаан хүчдэл зарцуулах ачаалалын харьцуулал нь тус бүр бараг 50%-тай байна. Харин 5 давхарын хийн компрессорын харцуулал нь 25%-тай бөгөөд 1 болон 5 давхрын шахагдсан хийн хоолойг холбон, 1-ын хийн компрессороос 5 давхарыг хийгээр хангавал эрчим хүч зарцуулалтыг ихээхэн багасгаж хэмнэх боломжтой юм.	Бүтэн жилд 62,000kW цагийн цахигаан хүчдэл хэмнэх боломжтой болно.
2	Хий алдалт	①Хийн компрессор орчмын хоолойн холболтын хэсэгт 6 цэгт хий алдагдаж байсан. ②Гурилын цехийн автомат хэмжигч төхөөрөмжийн хийн хоолойн холболтын хэсэгт 2 цэгт хий алдагдаж байсан.	①Яаралтай засварлах. ②Илэрсэн газруудын хий алдалтыг янзлахын зэрэгцээ хэт авианы алдалт хэмжигч худалдан авч цаашид тогтмол үзлэг, засвар хийх нь зүйтэй байна.	Баримжаа утга 1 цэгт 0.4kWh/h орчим алдалт гээд нийт 5 цэгт тооцож үзвэл, (0.4 X 5) X 6,000цаг = 12,000kWh/жил
3	Хийн даралт	7.7～6.8 бар	Том асуудал биш боловч 0.5 бараар буулгаж ЭХ хэмнэх боломж байгаа бөгөөд эхний ээлжинд чухал томоохон асуудлуудыг шийдээд, цаашид энэ тал дээр анхааран ажиллахыг хүсэж байна.	—
4	Цех тус бүрийн гэрэлтүүлэг	Байгалийн гэрлийг ашиглан, ихэнх өдрийн сүүн гэрлийг унтраасан байсан.	Гэрэлтүүлгийн хувьд, цахилгаан хэмнэх ухамсар сайтар хэвшсэн байгаа нь туйлын сайшаалтай хэрэг юм.	—
5	Улайсдаг гэрлийг өдрийн сүүн гэрлээр солих	Үйлдвэр дотор улайсдаг гэрэл зарим нэг газар харагдсан.	Үйлдвэр доторхи гэрлийг сайтар нягтлан үзэж улайсдаг гэрлийг сүүн гэрлээр шинэчлэх нь зүйтэй байна.	—

5-2-1. Хийн компрессорын төхөөрөмж

Шахагдсан хий болон хийн компрессорын хэмжилтийн судалгааны дүнг хүснэгтээр тусд нь үзүүлсэн бөгөөд компрессорын өөрчлөлт, хий алдалтын талаар дараах зүйлийг мэдээллэх байна.

(1) Ажиллуулах компрессорын өөрчлөлт

Ердийн үед 1 давхарын гурилын цехэд суурилуулсан 45 кВт-ын, 5 давхарын 18.5 кВт т-ын хийн компрессор нь зэрэг ажилладаг бөгөөд 1 давхарын хийн компрессор нь хийг илгээх ачаалалтай болон ачаалалгүй үеийн ажиллагааны харьцуулал нь тус бүр бараг 50-тай бараг 50 %-тай байв. Харин 5 давхарын хийн компрессорын хувьд ачаалалтай үеийн ажиллагааны харцуулал нь 25%-тай бүтээмжийн үзүүлэлт доогуур байгаа тул 1 болон 5 давхарын шахагдсан хийн хоолойг холбовол 1-ын хийн компрессороос 5-ыг хийгээр хангах боломжтой болж, цахилгаан зарцуулалтыг ихээхэн багасгаж, хэмнэх боломжтой юм.

Мөн үйлдвэрийн хувьд, хоолойг холбох ажлыг хийх талаар судлаж байгаа бөгөөд энэ удаагийн хэмжилтийн дүн, мэдээг ашиглан, цаашид сайжруулах талаар ажиллана гэж найдаж байна.



5 давхарын хийн компрессорыг зогсоосон тохиолдолд дараах байдлаар ЭХД-ийг хэмнэх тооцоо гарч байна.

(Одоогийн байдал)

1 давхар

Ачаалалтай үед √3×0.38V×83A×0.85×4000цаг=123.076kB/ц

Ачаалалгүй үед √3×0.38V×50A×0.70×4000цаг=64.499 kB/ц

Нийт 123.076kB/ц+64.499kB/ц=187.575kB/ц

5 давхар

Ачаалалтай үед √3×0.38V×83A×0.85×4000цаг=123.076kB/ц

Ачаалалгүй үед √3×0.38V×50A×0.70×4000цаг=64.499kB/ц

Нийт 123.076kB/ц+64.499kB/ц=187.575kB/ц

Одоогийн байдлын ЭХД-ний зарцуулалтын нийт дүн

123.076kB/ц+64.499kB/ц=187.575kB/ц

(Өөрчлөлтийн дараа)
1 давхарын компрессор нь 5 давхарын конпрессорыг хангахын тулд ачаалалтай үеийн ажиллагаа нь 10% -иар нэмэгдэн, ЭХД хэмнэлтийн хэмжээг дараахи байдлаар хэмнэх боломтой гэж үзэж байна.

Ачааллын үед √3×0.38V×28A×0.85×8000цаг＝125.313kB/ц
Ачаалалтай үед √3×0.38V×50A×0.70×4000цаг＝ 64.499kB/ц

Харин 5 давхарын хийн компрессорыг зогсоох учраас ЭХД-ний зарцуулалтын хэмжээ 0 болно.

(Хэмнэлтийн хэмжээ)
Хэмнэлтийн хэмжээ нь одоогийн зарцуулж байгаа цахилгаан хүчдэлийн нийт хэмжээнээс дээрхи өөрчлөлтийг хийсний дараа 1 давхарын конпрессорын цахилгаан хүчдэлийн хэмжээг хасаж тооцоолно.
187.575kB/ц－ 125.313kB/ц＝62.262kB/ц

Жилд нийт 62.000kB/ц-ын цахилгаан хүчдэлийг хэмнэх боломжтой болно.
Мөн хий алдагдаж байгааг зогсоосноор хэмнэлтийн хэмжээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ 15 кВт-ын 1 конпрессорыг дангаар нь ажиллуулахад бэрхшээлгүй болох юм.

(2) Шахагдсан хий алдагдаж байгаа газруудыг олж тогтоох

Хэт авианы хий алдалт хэмжигчийг ашиглан шахагдсан хийн алдагдаж байгаа цэгийг хайсны дүнд, хийн конпрессорын орчмын хоолойн холболтын хэсэгт 6 газар, автомат хэмжигч төхөөрөмжид 2 газар, нийт 8 газарт хий алдагдаж байгаа нь тогтоогдсон.
1 газраас ойролцоогоор 5 м3/ц гэж үзвэл 0.05 кВт/ц-ын цахилгаан хүчдэлээр нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл, хий алдаж буй 1 газрыг олж зассанаар жилд зарцуулагдах цахилгаан хүчдэлийн хэмжээг багасгаж, хэмнэх боломжтой болно.

0.5кВт/ц× 8×8000 цаг＝32.000 кВт/ц

Гэвч энэ удаагийн үзлэгээр үйлдвэрийн хэмжээнд нийт хий хэрэглэгдэж байгаа газрууд ыг хамруулж чадаагүй учраас цаашид алдагдаж байгаа бусад газруудыг хайж олох явдал нь чухал бөгөөд ингэснээр ЭХХ-ийн хэмжээ, үр дүнг нэмэгдүүлэх болно.

(3) Хийн компрессорын ажиллагаа хэмжилтийн үзүүлэлт
Энэ удаа хийсэн хэмжилтийн үзүүлэлтийг хавсралт-1 -д үзүүлэв.

5-2-3. Гэрэлтүүлэг

Гэрэлтүүлэгийн тухайд үйлдвэрийн таазыг байгалийн гэрэл нэвтрэх цонх болгосоноор өдрийн цагт гэрлийг хэмнэж байгаа ба шатны гэрэлтүүлэгт хүний хөдөлгөөн мэдрэгч бүхий унтраалга хэрэглэсэнээр ЭХХ-ийн үйл ажиллагааг идэвхтэй явуулж байгаа нь харагдаж байна.
Гэвч улайсдаг гэрлийг зарим нэг газарт хэрэглэсэн байгааг ойрын хугацаанд сүүн гэрлээр солих нь ЭХХ-ийн үр дүнг нэмэгдүүлэх болно гэж үзэж байна.
Гэрэлтүүлэг төхөөрөмжийн үзлэгийн дүнг хүснэгт 5-5-д үзүүлэв.

Хавсралт-1

моторын хүчдэл— А



моторын хүчдэл А



моторын хүчдэлА





Алтан тариа үйлдвэрийн уурын системийн схем зураг

Хавсралт -3





CYY ХК-ны үйлдвэрийн хийн компрессорын схем зураг

2011.9.27

Монгол улс Улаанбаатар хот
Агаарын бохирдлыг бууруулах
хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл
Эрчим хүч хэмнэлтийн баг

ӨГӨӨЖ- SWEET & BISCUIT дайран өнгөрөх ЭХДХ-ийн оношлогооны тайлан

1．Оношлогоо явуулсан газар
Компанийн нэр: ӨГӨӨЖ-SWEET & BISCUIT
Үйл ажиллагааны чиглэл: Талх, Biscuit-ын үйлдвэр

2．Оношлогооны хугацаа: 2011 оны 9 сарын 22 өдөр 15:00～16:00

3．Хариуцсан ажилтан
Ч. ӨЛЗИЙБАДРАХ (Маркетингийн ажилтан) бусад 2 ажилтан

4．Оролцогчид
НАЧА: Цолмон
ЖАЙКА-гын мэргэжилтэн: Такахаши
〃 : Хигаки

5．Үйлдвэрийн тухай
1）Талх болон бискэйтний үйлдвэр
2）1958 онд байгуулагдсан. Хувьчлагдсан.
3）Хуучны ЗХУ-ын тоноглол ихтэй болхоор янз бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлсээр байгаад өнөөг хүрсэн.
4）Итал, Польшийн төхөөрөмж болон ОХУ-ын сүүлийн үеийн тоноглол суурилуулаад байгаа.

6．Дайран өнгөрөх эрчим хүчний оношлогооны үр дүн.
1）Халааалтын эх үүсвэр нь цахилгаан болон халааалтын ус байх бөгөөд уурыг ашигладаггүй.
2）Цахилгаан шарах шүүгээ нь тасралгүй урсах загвартай. Гэвч зуухны том ам болон хажуу талын хаалтын хэсгүүд байгаа нь их хэмжээний дулаан алдаж АҮК-нд муугаар нөлөөлж байх магадлалтай. Шарах шүүгээнд зарцуулагдаж байгаа цахилгаан хүчдэлийн хэмжээ ихтэй байна гэж үзсэн. Хэмжилтийн үеийн цахилгааны хүчдэл 400А байсан. (260квт орчим)
3）Халааалтийн усыг ХЗАЗГ-аас түгээдэг бөгөөд 10/01-05/01-ний хооронд хэрэглээний халуун ус, халаатанд ашигладаг.
Гэхдээ ХЗАЗГ-аас түгээгдэж байгаа халааалтын усыг дулаан солицуур (2 хоолойт загварын дулаан солилцуур)-аар халааж үйлдвэрт өгдөг байна. Мөн халааалтын тоноглолын дулаалга зарим

хэсэгтээ байгаа боловч ихэнх хэсэгт дулаага хийгдээгүй байна.

4） Хийн компрессор 3 хэсэгт суурилуулсан байгаа нь бүгд жижиг шаардлагатай үед ачаалах ажиллагааны зарчимтай учраас ажиллах хугацаа бага илүү хэмнэлт гаргах боломжгүй.

5） Гэрэлтүүлгийн хувьд бүхэлдээ сайн нөхцөл байдалтай байна.

－Гэрэлтэй хэсгийн гэрлийг унтрааж байсан.

－Улайссан гэрлийн чийдэн байгаагүй.

7． ЭХДХ-ийн сануулга

1） Халаалтийн шугам хоолойг дулаалах тухайд үр ашиг өндөртэй гэдэг нь баталгаажсан байгаа учраас хөрөнгө оруулах боломжтой бол хэрэгжүүлэх нь зүйтэй гэж зөвлөсөн.

1 жишээ авч дулаалга хийгдээгүй байсан дулаан солилцуурын гадаргуунаас алдагдаж байгаа дулааны хэмжээ болон дуулаалснаар гарах үр дүн тооцоолж үзье.

[Тооцоолол]

－Дулаан солицуурын шугам хоолойг ямарч дулаалгагүйгээр тооцох зарим дулаалгатай хэсгийг тооцохгүй.

－Хэмжээ: 6inch

－Дулаалгагүй хэсгийн нийт урт: 30м

－1м тутамд алдагдах дулааны хэмжээ: 200ккал/м (Автоматаар тооцох)

－Нийт алдагдах дулааны хэмжээ: 200ккал/м×30м＝6,000ккал/ц

－Бүтэн жилийн алдагдах дулааны хэмжээ: 6,000ккал/ц×5,000ц/ж＝30,000,000ккал/ж

＝30.0Гкал/ж

－Дулаан алдалтыг бууруулах хэмжээ: 30.0Гкал/ж×80%×0.8＝19.2Гкал/ж

－Бүтэн жилд гарах зардлын хэмнэлтийн хэмжээ: 19.2Гкал/ж×20,886 төг/Гкал＝400,000 төг/ж

2） Одоогийн байдлаар автомат цахилгаан шарах шүүгээний АУК бага байх магадлалтай ч цаашид технологийн шинэчлэлээр өөрчлөн шинэчлэх үед сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна.

3） Одоо үйлдвэрт Япон хүний удирдлага доор 5S-ыг нэвтрүүлж байгаа бөгөөд энэхүү үйл ажиллагаа нь эрчим хүчний хэмнэлтэнд ч гэсэн нөлөөлнө гэж найдаж байна.

2011.9.27

Монгол улс Улаанбаатар хот

Агаарын бохирдлыг бууруулах

хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл

Эрчим хүч хэмнэлтийн баг

ЖҮРҮР (Тортны үйлдвэр) Эрчим хүч дулаан хэмнэлтийн оношлогооны тайлан

1．Оношлогоо явуулсан газар

Компанийн нэр: ЖҮРҮР

Үйл ажиллагааны чиглэл: Тортны үйлдвэр

Хаяг: Хан-Уул дүүрэг, 3-р хороо, ажилчны гудамж-137 “ЖҮРҮР” барилга, УБ хот, Монгол

2．Оношлогооны хугацаа: 2011 оны 9 сарын 23-ны өдөр 12:00～13:00

3．Хариуцсан ажилтан

н. Маралхүү Тогтохбаяр (Салбарын дарга)

4．Оролцогчид

НАЧА: Цолмон

ЖАЙКА мэргэжилтэн: Такахаши

〃 : Хигаки

5．Үйлдвэрийн тухай

Тортны үйлдвэрийн газрын талбай 1,500 м^2-тай жижигхэн үйлдвэр.

6．Дайран өнгөрөх эрчим хүчний оношлогооны үр дүн.

1）Дулааны эх үүсгүүр нь цахилгаан ба халаалтын ус бөгөөд уурын хэрэглээ байхгүй.

2）Тортны цахилгаан шарагч нь олон давхар тавцантай бөгөөд гадна талын эх биеийн темпертур багатай байгаа нь АУК сайтай байхаар харагдсан. (Шарагч шүүгээний дотор талын темпертур:150～200℃)

3）Халаалтыг ХЗАЗГ-аас 10/01-05/01-ны хооронд авдаг бөгөөд халуун ус, буцалмал ус зэрэгт ашигладаг. Халаалтын темпертур:

－Өгөх: 80～90℃

－Хэрэглээний халуун ус: 50～60℃

－Халаалт: 80～90℃？

Гэхдээ ХЗАЗГ-аас түгээж байгаа халаалтыг дулаан солилцуур (2 давхар хоолой)-аар дамжуулан үйлдвэрт өгч байгаа боловч дулаан солилцуурын хүчин чадал хүрэлцэхгүй байгаа байдалтай

байна.

Мөн дулааны тоноглолын дулаалгын тухайд хэсэгхэн газарт л дулаалгатай төдийхөн байна.

4）Хийн компрессороор 1 ширхэг байх бөгөөд энэ нь хий дутагдалтай болох үед нөхөх зарчимтай учраас цахилгаан хэрэглээ бага. Гэхдээ хийн компрессорын даралт 6.7bar байсан.

5）Гэрэлтүүлгийн тухайд нэлээн сайн

ерөнхийдөө дараах байдалтай байсан.

－Гэрэлтэй хэсэгт гэрлийг унтраасан байсан.

－Өдрийн гэрэл хэрэглэж байсан. (Флюресенц ламп)

－Улайссан чийдэнгийн шил харагдаагүй.

－Гадна талын 2 гэрэл (HID ламп) өдрийн цагаар асаалттай байсан. Энэ нь унтраахаа мартсан тохиолдол таарсан байсан.

7．Үйлдвэрт хийсэн ЭХДХ-ийн зөвөлгөөний агуулга

1）Халаалтын дулаан солилцуурын хүчин чадал хүрэлцэхгүй байгаа асуудалд баруун талын зурагт үзүүлсэн ялтсан бойлероор сольж тавьсан нь дулаан дамжуулах АУК өндөр мөн халах гадаргууны талбай бага (эх биеэс алдагдах дулаан бага) болж зай бага эзэлнэ.

Мөн дулааны ялтсан бойлерыг ЖАЙКА-гын хоёр шатлалтай хөнгөлттэй зээлийг ашиглах боломжтой гэж зөвлөсөн.

2）Халаалтын тоноглолын дулаалгын тухайд халаалтын усны темпертур тиймч их өндөр биш учраас хөрөнгийн эргэн нөхөлтийн хугацаа уртсах талтай. Иймээс ажилтангуудын идэвхи оролцоогоор хэрэгжүүлсэн нь зардал хэмнэнэ гэж бодож байна.

3）Гадна талд асаалттай байсан 2 гэрлийг тэр дор нь унтраасан байсан. Гэхдээ гэрлээ унтраахаа мартахаас сэргийлж унтраалгын дээр сануулга бичиг байрлуулж мөн ажилтанд хариуцуулах шаардлагатай.



Ялтсан дулаан солицуурын бойлерын жишээ

ЖАЙКА ОУБ, Монгол улс, Улааанбаатар хот

Агаарын бохирдлын хяналтын чадамжийг бэхжүүлэх төсөл

ЭХХ баг

2011 оны 9 сар

ДЦС 3-т хийсэн ЭХХ-н шинжилгээ оношилгооны үр дүнгийн тайлан

1. Зорилго

ЖАЙКА ОУБ, Монгол улс, Улааанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадамжийг бэхжүүлэх төслийн үйл ажиллагааны хүрээнд хэмжилтийн багаж төхөөрөмжийг ашиглан ДЦС 3-н зуухны эргэн тойронд дулаалга болон дулаан тэсвэрлэлтийн нөхцөл байдлын оношилгоо шинжилгээг явууллаа.

2. Оношилгоо хийсэн огноо:

2011 оны 9-р сарын 28 өдөр（Пү）10:00～11:30

3. Харилцагч талын төлөөлөл

ДЦС 3：Mr. Boldsaikhan（Экологийн инженер）

4. Хэмжилт хийсэн:

НАЧА　　：Ms. Tsolmon

ЖАЙКА　　：Такахаши（хэмжигч）

Хигаки Садао（хэмжигч）

5. ЦС-н товч агуулга

ДЦС 3-н тоног төхөөрөмжийн товч агуулгыг хүснэгт 1 харуулав.

Хүснэгт 1：ДЦС 3-н төхөөрөмжүүдийн товч танилцуулга

Агуулга	Нам даралтын шугам	Өндөр даралтын шугам
Зуухны тоо &（дугаар）	6 ш（1 ~6）	7 ш（7 ~12）
Зуухны үзүүлэлт －Уурын хэмжээ －Уурын даралт －Уурын темп	 75 t/h 40 kg/cm2 440 ℃	 220 t/h 100 kg/cm2 540 ℃
Зуухны нүүрсний зарцуулалт	16~17 t/h	35~40 t/h
Турбины чадал ×Зуухны тоо	12 MW×4 ш（Нийт：48 MW）	25 MW×4 ш（Нийт：100 MW）

Тоос баригч болон тоо ширхэг	Скрубер 2 ш	Скрубер 4 ш

6. ДЦС-н байршил

ДЦС-н байршилыг Зураг 1-т харуулав.

Зураг 1：ДЦС 3-н байршил

Эх үүсвэр：Google Earth

6. Оношилгооны агуулга

1) Оношилгоонд хамрагдсан төхөөрөмж：8-р зуух

2) Ашигласан хэмжилтийн багаж хэрэгсэл

① Термокамер (NEC AVIO Infrared Ray Technology Co. Ltd FW30)

② Хэт ягаан туяаны температур хэмжигч (HIOKI 3419)

Зураг 2：Термо камер

Тайлбар: －Хэмжилт хийх температурын хүрээ：-20～350℃

－Цацрагийн коеффицент (Emissivity) 0.85-р тохируулсан

－ орчины температурыг 20℃-т тохируулсан.

Зураг 3：Температур хэмжигч

Тайлбар: －Хэмжилт хийх температурын хүрээ：-35～500℃

－ Цацрагийн коеффицент (Emissivity) 0.85-р тохируулсан.

3) Хэмжилт хийх дараалал

① Термокамерийг ашиглан зуухны эх бие болон уурын хоолой, агаарын хоолой, тэжээлийн ус болон уурын шугам хоолойны изоляцийн зураг болон энгийн фото зураг авч гадаргуун температурын нөхцөл байдлыг хэмжих.

② Цацрагийн температур хэмжигчээр дээрх газруудын температурыг хэмжих

③ Хяналтын өрөөнд зуухны ажиллагааг шалгах

7. Хэмжилтийн үр дүн

1) Зуухны эх бие болон уурын тогооны эргэн тойрон мөн агаарын хоолой, уур болон тэжээлийн усны шугам хоолойн изоляцийн зураг (изоляцийн зураг болон энгийн фото зураг)-н тухайд Зураг 1～8-д үзүүлсэн бөгөөд дулаалга хийгдээгүй хэсэг газар болон уур халаагчийн оролтын хэсэгт өндөр температуртай байсан.

2) Цацрагийн температур хэмжигч багажийг ашиглан хийсэн хэмжилтээр бүх хэсгийн дулааны хүрээ дараа байдалтай байсан бөгөөд хэсэг газрын дулаалга болон дулаан тэсвэрлэх материал муу хийгдсэн газруудад өндөр температуртай байсан.

① Зуухны эх биеийн гадаргуу（Бүхэлдээ）：50～70 ℃

② Уур халаагчийн оролтын хэсэг болон зуухны эх биеийн гадаргуу：100～120 ℃

③ Уурын тогооны эх биеийн гадаргу：40～50 ℃

④ Үндсэн уурын шугам хоолойн гадаргу：45～55 ℃

⑤ Тэжээлийн усны шугам хоолойн гадаргуу：30～35 ℃

3) Зуухны галлагааны нөхцөл байдал

8-р зуухны галлагааны нөхцөл байдлыг Зураг 9～12-т харуулав.

4) Бусад

① Шугам хоолойн дулаалгын материалд нүдээр харах хүрээнд азбест хэрэглэсэн байв.

② Азбест дулаалгын гүйцэтгэлийн тухайд хэв бэлдмэл ашиглалгүйгээр азбест болон нунтаг гипсийг хольж, усаар зуурсан зуурмагийг гадаргуунд шавсан байсан бөгөөд энэхүү аргачлал нь хотын доторх дулааны шугам хоолойн дулаалгатай адил аргаа хийгдсэн байв.



Зураг 1 : Зуухны арын ханын гадна хэсэг



Зураг 2 : Экономайзерийн зуух талын гадны хэсэг



Зураг 3 : Агаар халаагчийн гаралтын агаарын хоолойн дулаалгагүй флянзтай хэсэг

Тайлбар : Зураг 1～3-н тухайд тухайн газарт харанхуй байсан тул термокамерийн энгийн тохиргоогоор зураг авах боломжгүй байсан.



Зураг 4-1 : Уур халаагчийн оролт зуухны эх бие

Зураг 4-1 : Уур халаагчийн оролт зуухны эх бие



Зураг 5-1 : Уурын тогооны эргэн тойрон

Зураг 5-1 : Уурын тогооны эргэн тойрон



Зураг 6-1 : Уурын тогооны үйлчилгээнй амны хэсэг



Зураг 6-1 : Уурын тогооны үйлчилгээнй амны хэсэг



Зураг 7-1 : Экономайзерийн гаралт, тэжээлийн усны шугам

Зураг 7-2 : Экономайзерийн гаралт, тэжээлийн усны шугам



Зураг 8-1 : Үндсэн уурын шугам

Зураг 8-2 : Үндсэн уурын шугам



Зураг 9 : Зуухны галлагааны нөхцөл байдал



Зураг 10 : Зуухны галлагааны нөхцөл байдал

